

УУРАГ ЭРДСИЙН ШАХМАЛ ТЭЖЭЭЛ

I. Уураг эрдсийн шахмал тэжээл

Энэхүү тэжээлийг дан бэлчээрт буй хонь, ямаа, үхэр зэрэг хивэгч малд өвөл хаврын улиралд, мөн байран маллагаатай малыг чанар муутай бүдүүн тэжээлээр тэжээх үед нэмэгдэл болгон ашигладаг.



Зураг 1 Уураг эрдсийн шахмал тэжээл

Уураг эрдсийн шахмал тэжээлийн ач холбогдол нь:

1. Малын өсөлт, хөгжилт, нөхөн үржихүй, ашиг шимд чухал ач холбогдолтой тэжээлд дутагдаж буй эрдсүүдийг агуулдаг.
2. Мал амьтны өсөлтөнд хэрэгтэй уургийн 50 хувийг хангаж чадахаас гадна сүүний гарцыг нэмэгдүүлнэ.
3. Мал амьтны хэрэгцээт энергийн 45 хувийг хангахаас гадна махан ашиг шимийг сайжруулна.



Зураг 2 Хурга долооц долоож байгаа нь

II. Уураг эрдсийн шахмал тэжээл хийх тухай

Уураг эрдсийн шахмал тэжээлд шээг 4-10%, чихрийн манжингийн шаар 0-45%, хивэг, бүдүүн тэжээл 10-30%, давс эрдэс бодис 0.5-30%, барьцалдуулагч бодис болох цемент, шар шавар, бентонит 6-15% болон бусад хольцыг 10-20% хүртэл оруулж болно.

Энэхүү түгээмэл хэрэглэгддэг жорыг ашиглан тус бүр нь 2 кг жинтэй 5 ширхэг долооц хийх үлгэрчилсэн жорыг нэгдүгээр хүснэгтэд үзүүлэв.

1. Уураг эрдсийн шахмал тэжээлийн найрлага


Түүхий эд	Хэмжээ, кг	Ноогдох хувь
Шээг	0.4	4
Улаанбуудайн хивэг	3	30
Давс	5	50
Барьцалдуулагч (цемент)	0.8	8
Ясны гурил	0.8	8
Нийт	10	100

Хэрэв шээг байхгүй бол түүнийг үхрийн шээсээр орлуулж болно. Үхрийн шээсэнд 4% шээг байдаг. Бүх түүхий эдийг заавал нунтаглана. Дараа нь тэдгээрийг хольж жигдрүүлэн нэг төрлийн болгоно. Жигдэлсэн хольцон дээр ус эсвэл чихрийн манжингийн шаарыг нэмж зуурна.

УУРАГ ЭРДСИЙН ШАХМАЛ ТЭЖЭЭЛ

Уураг эрдсийн шахмал тэжээл бэлтгэх бүдүүвч

- 1 • Түүхий эдүүдийг бэлтгэх
- 2 • Түүхий эдүүдийг нунтаглах
- 3 • Түүхий эдүүдийг хэмжих
- 4 • Түүхий эдүүдийг хольж жигдрүүлэх
- 5 • Ус нэмж зуурах
- 6 • Хэвэнд цутгах
- 7 • Хатааж хадгалах



Зураг 3. Уураг эрдсийн долооц хийхэд хэрэглэгдэх багаж, сав

Зуурмагийг хэвэнд хийж шахна. Шахмал тэжээлийн хэмжээ 1-5 кг байж болно. Тэжээлийг хэв саванд наалдуулахгүй, хялбар салгаж авахын тулд гялгар цаас дэвсэж өгөх хэрэгтэй. Дараа нь хольцыг хатуу болтол маш сайн шахаж нягтруулна. Хэрэв цаас ашигласан бол мал түүнийг ямар ч асуудалгүй идчих учраас түүнийг үлдээж болох юм. Харин гялгар уутыг заавал салгаж авна. Хэвэнд оруулж шахаж бэлдсэн тэжээлийг хуурай, сүүдэр газар тавьж хатуу болтол нь сайн хатааж хадгална.

Эмхэтгэсэн: Эва Шлект (Германы Гетингений болон Касселийн Их Сургууль), Норовсамбуугийн Тогтохбаяр (Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль), Цэвэгмэдийн Мөнхнасан (Германы Касселийн Их Сургууль)

Эх сурвалж: Тогтохбаяр, (2006). Уураг эрдсийн шахмал тэжээлээр тэжээх замаар малын ашиг шимийг сайжруулах нь, IAEA-TECDOC-1495. Pp-69-76.

III. Мал амьтныг тэжээх нь

Уураг эрдсийн шахмал тэжээлээр үхэр, хонь, ямаа, сарлаг зэрэг хивэгч малыг тэжээнэ. Харин нэг тасалгаат ходоодтой мал амьтанд өгч болохгүй (Зураг 4).



Зураг 4. Эдгээр амьтанд өгч болохгүй

Шахмал тэжээлийг мал амьтанд томоор үмхүүлэхгүй, зөвхөн долоолгохын тулд бага зэрэг том хэмжээтэй хайрцаганд хийнэ. Мал шахмал тэжээлийг үе үе бага багаар долооно. Тэжээлд давсны орц их байх учраас идэмж нь хязгаарлагддаг. Мөн тэжээлийг шууд газар дээр тавьж өгч болохгүй.



Зураг 5. а) Тэжээлийг хайрцаганд хийж долоолгож байгаа нь, б) Тэжээлийг шууд газар дээр тавьж өгч болохгүй.